

ГАЗРЫН ДОРойТЛЫГ ТЭГЛЭХ НЬ

Бизнест зориулсан асуудлын товчоон

Энэхүү товхимолыг ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн Хүрээлэнгийн Цөлжилтийн Судалгааны Төвөөс эрхлэн гаргаж байна. Товхимолын ерөнхий агуулгыг судалгааны олон салбарын эрдэмтэн судлаачид хянаж бэлтгэсэн бөгөөд мэдээлэл өгөх болон олон улсын хамтын нийгэмлэгээс гаргаж буй нийтлэг зорилтыг таниулах зорилго агуулсан болно.

Товхимолд дурьдсан арга хэмжээ, зөвлөмжийг зөвхөн мэдээлэл түгээх, санаа өгөх зорилгоор оруулсан бөгөөд БОАЖЯ, НҮБ-ын ХХ-ийн албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.



**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**



Энэхүү товхимолыг БОАЖЯам ба НҮБХХ-ийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” МОН/16/301 төслийн дэмжлэгээр хэвлэв.

АГУУЛГА

Оршил

Бидний өмнө тулгарч буй сорилт

Газрын доройтол бизнест яагаад хамааралтай гэж?


Газрын доройтлыг тэглэх нь: Шийдэл?

Газрын доройтлыг тэглэснээр бий болох бизнес боломж

Холбогдох зорилт ба санаачлагууд

Бодлогыг хэрхэн тэлэх вэ?

Дүгнэлт ба дараагийн алхам




ОРШИЛ

Газрын доройтол, цөлжилтийг бууруулах олон улсын хэд хэдэн үүсгэл санаачлага сүүлийн жилүүдэд хэрэгжсэн байдаг. Тухайлбал, Бонны Сорилт, Нью Йоркийн Ойн Хэлэлцээр зэрэг нь цөлжсөн болон доройтсон ойг нөхөн сэргээх, Айчигийн Биологийн төрөл зүйлийн Зорилтууд доройтсон экосистемүүдийг нөхөн сэргээх, хамгаалахыг уриалсан байдаг. Эдгээр нь цөм газрын доройтлыг тэглэх зорилтод хувь нэмэр оруулж экосистемийн үйлчилгээг тогтвортой өсгөх, эрүүл, бүтээмжит газрын нөөц, баялгийг хадгалахад чухал үүрэгтэй оролцож байна.

2015 онд газрын доройтлыг тэглэх зорилтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Тогтвортой Хөгжлийн Зорилт болгон дэвшүүлсэн. Ингэхдээ энэ зорилтод хүрэхэд бизнесийн байгууллагуудын тус дэмжлэг их болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэсэн хэдий ч бизнесийн байгууллагууд яагаад, хэрхэн энэ асуудалд хувь нэмрээ оруулж чадах талаархи мэдээлэл дутмаг хэвээр байгаа юм.

Энэхүү мэдээллийн товхимолын гол зорилго нь дээрхи асуултад зөв хариултыг өгөх замаар хувийн хэвشلүүдийн мэдлэгийг тэлж, газрын доройтол, тэр дундаа газрын доройтлыг тэглэх зорилтын талаархи ойлголтыг олгоход чиглэнэ. Энэ бүтээлд газрын нөөцөд суурилсан тогтвортой байдлыг хангах нөхөн сэргээлт болон менежментийн арга хэмжээнд дэмжлэг болох энгийн бөгөөд практик ач холбогдолтой шалгуур үзүүлэлтүүдийг танилцуулсан болно. Энэхүү товхимлоор дамжуулан газрын доройтлын асуудалд бизнесийн орчны анхаарлыг хандуулж цаашид газрын доройтлыг тэглэх зорилтод тэдгээрийн дэмжлэгийг олоход чиглэсэн бидний анхдагч харилцааны хэрэгсэл болно.



ГАЗРЫН ДОРОЙТЛЫН УЧИР ШАЛТГААН

Газрын доройтлын шалтгаанд ой мод огтлол, бэлчээрийн талхлагдал, үр тариа дагнан тариалах (монокультур), давсжилт, хөрс, усны бохирдол, бордоо болон химийн бодисын зохисгүй хэрэглээ, тариалангийн зүй бус аргууд, хөрсний элэгдэл, эдвдрэл зэрэг багтана.

(ELD, 2014)



БИДНИЙ ӨМНӨ ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цөлжилттэй Тэмцэх Конвенци (НҮБ ЦТК)-оос гаргасан дүн мэдээгээр дэлхийн хэмжээнд бүтээмжит талбайн 25 % нь аль хэдийнээ доройтсон бөгөөд үүнээс үүдэх эдийн засгийн алдагдал нь жилд 40 тэрбум ам доллартай тэнцэж байна. Ихэнхи бүс нутгуудад хөрсний чанартай холбоотой асуудлууд нийт тариаланд ашиглагдаж буй газрын 50 хувьд нь илэрч байгаа бөгөөд эдгээр нь Африкийн Сахар орчмын бүс, Өмнөд Америк, Зүүн өмнөд Ази, Хойд Европт илүүтэй явагдана (FAO, 2011).

Монгол орны хувьд газрын доройтолд өртөөд байгаа газрын хэмжээ 2015 оны байдлаар 76.9 хувьтай тэнцэж байгаа бөгөөд үүнээс бүтээмжит буюу хөдөө аж ахуй болон үйлдвэрлэлд ашиглагдахуйц талбай 70 орчим хувь байна (Мандах нар, 2016).

Жил бүр хүний шууд нөлөөн дор 12 сая га газар буюу Их Британийн нийт нутаг дэвсгэрийн тэн хагастай тэнцэх газар нутаг шинээр доройтож байна (UNCCD, 2013). Газрын

доройтлын хамгийн түгээмэл хэлбэр нь ус, салхины элэгдэл, эвдрэл, тэдгээрээс улбаалах хөрсний хими болон физик доройтол болно (ELD Initiative, 2013a).

Газрын доройтол нь хүнсний аюулгүй байдал алдагдах, нүүрстөрөгчийн ялгаруулалт нэмэгдэх, биологийн төрөл зүйл хомсдох, хортон шавжийн олшрол өсөх, цэнгэг усны нөөц, хангамж буурах, уур амьсгалын өөрчлөлтөнд эмзэг байдал нэмэгдэх зэрэг нийгэм болон эдийн засагт шууд нөлөө их үзүүлнэ (ELD Initiative, 2013b).


Өнөөдөр газарт үзүүлэх дарамт нэмэгдэж байгаагаар холбоотойгоор хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангаж чадах эсэхэд эргэлзээ төрөх төвшинд хүрээд байна. Газрын доройтолтой холбоотойгоор газрыг алдагдсан баялаг гэж тооцох, газрын доройтлыг бууруулах өртөг зардал болон эргэн төлөлтийг бүрэн ойлгохгүй байгаагаас гадна нийтийн болон хувийн хэвшлийн хүрээнд аливаа шийдвэр гаргах үйл явцад дээрхи асуудлыг тусгахгүй явж ирлээ.

ГАЗРЫН ДОРОЙТОЛ ГЭЖ ЮУ ВЭ?

“Газрын доройтол гэдэг нь хүний үйл ажиллагаа, байгалийн үйл явц, түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйлийн хомсдолын хавсарсан нөлөөгөөр газрын биологийн болон эдийн засгийн бүтээмжийн чадавхи буурах, алдагдах үйл явц юм.

(UNCCD, 2013)

МОНГОЛ ОРНЫ ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН ДОРОЙТЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ



Монгол орны цөлжилт, газрын доройтлыг байгаль, уур амьсгал, нийгмийн голлох хүчин зүйлийн хүрээнд хийсэн үнэлгээгээр 2015 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртөөд байгаа бөгөөд үүнээс хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газар 23.1 хувийг эзэлж байна. Цөлжилт, газрын доройтол нэмэгдсэн газруудад Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, өмнийн болон дорнын говийн нутаг хэвээр хадгалагдан үлдэж байгаагийн зэрэгцээ өмнөх үеийн судалгаагаар тогтоогдсон Орхон-Сэлэнгийн сав нутаг, Хэрлэн голын сав, Дорнод Монголын хээрийн муж, Төв Халхын тэгш өндөрлөгийн хэмжээнд доройтлын үйл явц нэмэгдсэн дүнтэй байна.

ГАЗРЫН ДОРОЙТОЛ БИЗНЕСТ ЯАГААД ХАМААРАЛТАЙ ГЭЖ?

ЭРСДЛҮҮД

Газрын доройтлоос улбаалан үүсэх хувьсал өөрчлөлт нь нөөцийн үнэ өртөг, хүртээмж зэрэгт нөлөөлөх замаар бизнесийн нэгжүүдийн өртөгийн бүтэц, ашиг орлогод шууд нөлөөлнө. Энэ нь газраас шууд ашиг хүртэх газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, ойн аж ахуй зэрэг салбарт хамаарахаас гадна нийлүүлэлт болон үнийн хэлхээгээр дам холбогдох аялал жуулчлал, химийн үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрлэл төдийгүй даатгалын болон санхүүгийн салбарт ч тусгалаа олно.

ГАЗАР БА НҮҮРСТӨРӨГЧИЙН ШИНГЭЭЛТ

Бууц бордоо ашиглах, хөрс боловсруулах, ургамал нөмрөгийг хөндөх зэрэг газрын менежментийн аливаа үйл ажиллагаа нь хөрсөн дэх нүүрстөрөгчийн нөөцийг өөрчилж хөрсний тогтолцоонд явагдах нүүрстөрөгчийн урсгалд нөлөөлнө. Менежментийн ямар үйл ажиллагаа явуулж байгаагаас хамааран газар нь нүүрстөрөгчийн эх үүсвэр эсвэл шингээгч болдог.

Энэ өнцөгөөс харвал дараах асуудлууд анхаарлын төвд байхыг шаардана.


- 1 Бүтээмжит үйлдвэрлэл** — бага нөөцөөс илүү ихийг үйлдвэрлэх шинэлэг шийдлүүдийг санал болгоно;
- 2 Дасан зохицох** — Тариаланчид болон хөдөөгийн ард иргэдийн уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадварыг сайжруулах сайн туршлагуудыг нэвтрүүлэхийг шаардана;
- 3 Нөхөн сэргээлт** — Бүтээмжийг нэмэгдүүлэх болон доройтсон экосистемийг сайжруулах зорилгоор нөхөн сэргээнэ;
- 4 Газрын тогтвортой менежмент** — хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгах, бууруулах газрын менежментийн арга хэлбэрүүдийг түгээн дэлгэрүүлнэ.

Зарим эрсдлүүдийг дурьдвал:

- **Бүтээмж буурах** нь газраас хамааралтай үйлдвэрлэл эрхлэгчид болох ХАА, газар тариалан, ойн аж ахуйд шууд нөлөөлөн үнийн хэлхээгээр дамжин үнэ өртөг, хүртээмжийг өөрчилснөөр бусад салбарт ч нөлөөлнө;
- **Түүхий эдийн тоо, хэмжээ, хүртээмж буурах** нь бизнесийн доод түвшнүүдэд шууд нөлөөлөн үнийн зохицуулалтыг мөн хөндөнө;
- **Экосистемийн үйлчилгээ буурах** нь усны чанар, хангамж буурах, үер ус, хөрсний гулсалт зэрэг гамшигт үзэгдлүүдэд эмзэг болох зэрэг хэлбэрээр бизнесийн тогтмол үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлнэ;
- **Улс төрийн тогтворгүй байдал ба түүнтэй холбоотой нийгмийн асуудлууд** нь нийгмийн эрүүл мэнд, ядуурал, дүрвэлт, цагаачлал, хөдөлмөрийн нөөцийн бууралт, зөрчилдөөн зэргийг араасаа дагуулна;
- **Хууль, зохицуулалтын арга хэмжээ** тухайлбал, экосистем, газрын доройтолд заналхийлэлд хариу болгон Засгийн газруудаас тогтоох татвар, хураамжийн бодлого нь мөн л бизнесүүд, ялангуяа суурь үйл ажиллагаанд сөрөг нөлөөлнө.

Эх үүсвэр: ELD Initiative, 2013





БИЗНЕСИЙН САЛБАРУУД БА ТЭДГЭЭРИЙН ЭРСДЛИЙН ТҮВШИН

ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ САЛБАР

- ХАА, ойн аж ахуй, уул уурхай
- Барилга ба метериалын үйлдвэрлэл
- Хүнс, ундааны үйлдвэрлэл
- Аж үйлдвэрлэлийн бараа ба үйлчилгээний салбар
- Амралт, аялал, жуулчлалын салбар (нисэх, тээвэр, зочид буудал, зоогийн газар г.м.)
- Өрхийн хэрэглээний бараа үйлдвэрлэл (цахилгаан бараа, тамхи, хувцас г.м.)
- Өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэл (ус, усан хангамж, цахилгаан, эрчим хүч)

ДУНД ЗЭРГИЙН ЭРСДЭЛТЭЙ САЛБАРУУД

- Химийн үйлдвэрлэл
- Эрүүл мэндийн салбар (багаж, төхөөрөмж, үйлчилгээ)
- Даатгал
- Газрын тос ба байгалийн хийн салбар
- Үл хөдлөх хөрөнгийн салбар
- Худалдаа

Эх үүсвэр: ELD Initiative, 2013



Монгол Улсын хэмжээнд 191.2 мянган хавтгай дөрвөлжин километр газарт газрын доройтлоос зайлсхийх шат дараатай арга хэмжээ авснаар ХАА, газар тариалангийн үйлдвэрлэлийг одоогийн түвшнөөс хавьгүй нэмэгдүүлэх боломж бий.

БОЛОМЖУУД

Газрын нөөцийн эрүүл ахуй, бүтээмжийг тогтвортой байлгах, тордон сайжруулах, нөхөн сэргээх нь газарт түшиглэн бизнесээ явуулах компани, аж ахуйн нэгжүүдэд шинэ боломжийг нээн илрүүлж өгнө. Газрыг зохистой ашигласнаар бизнест үзүүлэх газрын доройтлын нөлөөг бууруулахаас гадна илүү сайн, илүү бүтээмжтэй үйлдвэрлэлийн шийдлийг олгох нь дамжиггүй.

Газрын доройтлыг бууруулах боломжууд дэлхийн өнцөг булан бүрт бий болсон. Дэлхийн хэмжээнд хэдийн доройтсонд тооцогдож байгаа 2 тэрбум га талбайн тэн хагасыг нөхөн сэргээх замаар эргүүлэн үйлдвэрлэлд ашиглах боломжтой байна (www.wri.org). Өөрчлөлтийг хийх, газрын менежментийн арга, үйл ажиллагааг сайжруулах хүсэл эрмэлзлэл бий болсноор газрын нөөц баялаг, түүний бүтээмжийг бүрэн ашиглах бизнесүүд болон бусад тоглогчдын эрхийг нэмэгдүүлнэ.

ДОРОЙТСОН ГАЗРЫГ СЭРГЭЭХ БА НӨХӨН СЭРГЭЭХ

Сэргээх гэдэгт эх газрын экосистемийн эрүүл ахуй, нэгдмэл чанар, тогтвортой байдлыг хангах зорилгоор сэргэн ургалтыг дэмжих буюу нэмэгдүүлэх үйл ажиллагааг ойлгоно. Газрыг сэргээхийн гол зорилго нь нутаг дэвсгэрийн байгалийн унаган төрхөд аль болох ойр төлөвт эргүүлэн авчрахад оршино.

Нөхөн сэргээх гэдэгт газрын чадавхийг сайжруулах замаар экосистемийн зарим бүтээгдэхүүн ба үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг ойлгоно. Газрыг нөхөн сэргээх үйл ажиллагаа нь нутаг дэвсгэрийг зайлшгүй унаган байдалд эргүүлэн авчрахад чиглэсэн байхыг шаарддаггүй.

Эх үүсвэр: Global Mechanism, 2015

ГАЗРЫН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТ (ГТМ)


ГТМ гэдэг нь газрын доройтолд үзүүлэх хариу үйлдэл бөгөөд доройтлыг бууруулах, доройтсон газрыг нөхөн сэргээхэд хувь нэмэр оруулах үйл ажиллагаа юм.

ГТМ-ийн олон янзын тодорхойлолтыг өнгөрсөн хугацаанд гаргасан байдаг.

НҮБ-ын ЦТК-ийн тодорхойлсноор “ГТМ гэдэг нь хөрс, ус, ургамлан нөмрөгийг үйлдвэрлэлд зохистой ашиглах замаар өнөөгийн болон ирээдүй хойч үеийнхний хэрэгцээг дэмжих үйл ажиллагаа юм. ГТМ нь цөлжилт, газрын доройтолд өртөж буй нийгмийн бүлгийн нийгэм-эдийн засгийн сайн сайхан амьдралыг бүрдүүлэх, экосистемийн үйлчилгээг тогтвортой байлгах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг дээшлүүлэхэд чиглэнэ”.

Эх үүсвэр: UNCCD, 2011

Даян дэлхийн ерөнхий чиг хандлагаар бол хүн ам өсөн нэмэгдэж харин газрын нөөц, чанар, хүртээмж буурах төлөвтэй байгааг анхааран үзвэл газрын тогтвортой менежментийг нэвтрүүлж газрын бүтээмжийг өсгөх, газрын доройтлыг бууруулж, хэдийн доройтсон газрыг нөхөн сэргээх нь хожим их ашиг авчрах боломжийг бий болгоно. Газрын тогтвортой менежментийг газар тариалангийн салбарт өргөн нэвтрүүлснээр дэлхийн үр тарианы үйлдвэрлэлийг 1.4 их наяд доллараар өсгөх боломжтой гэсэн тооцоо бий (ELD Initiative, 2013). Мөн түүнчлэн жил бүр 12 сая га доройтсон талбайг нөхөн сэргээснээр 20 жилийн дотор дэлхийн нүүрстөрөгчийн ялгаруулалтын хэмжээг 20 орчим хувиар бууруулж эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой (Global Mechanism, 2015).



ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ ТЭГЛЭХ

ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ ТЭГЛЭХ

Газрын доройтлыг тэглэх гэдгийг “экосистемийн үйлчилгээг дэмжих эрүүл, бүтээмжит газрын нөөц, хэмжээ тогтвортой бөгөөд тодорхой цаг хугацаа, орон зайн масштабд өсөх төлөв байдал” гэж тодорхойлсон байна.

ГДТ Засгийн газар хоорондын
ажлын бүлгийн тодорхойлолт

БИДНИЙ ХҮСЧ БУЙ ИРЭЭДҮЙ – РИО +20

“Бид нэн даруй газрын доройтлыг бууруулах шаардлагатайг хүлээн зөвшөөрч байна. Энэ үүднээс бид тогтвортой хөгжлийн хүрээнд газрын доройтолгүй дэлхийг бий болгохыг зорин ажиллана. Энэ нь төрийн болон хувийн хэвилийн салбараас санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх ажлыг хурдасгах юм”.

Эх үүсвэр: Нэгдсэн Үндэстний Байгууллага, 2013

ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ ТЭГЛЭХ НЬ: ШИЙДЭЛ?

ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ ТЭГЛЭХ ЗОРИЛТЫН ҮҮСЭЛ

1994 онд батлагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цөлжилттэй Тэмцэх Конвенци нь байгаль орчин ба хөгжлийн асуудлыг газрын тогтвортой менежментэд уялдуулах олон улсын эрхзүйн баримт бичиг юм. Энэхүү хэлэлцээрийн гол зорилго нь “ядуурлыг бууруулах, байгаль орчны тэнцвэрийг хадгалах зорилгоор эмзэг бүс нутагт гангийн нөлөөг багасгаж цөлжилт, газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх даян дэлхийн хамтын ажиллагааг бий болгох”-од оршино (UNCCD, 2008).

2012 онд НҮБ-ын ЦТК-иос Рио+20 бага хурлын хүрээнд газрын доройтлыг тэглэх зорилтын үзэл санааг танилцуулсан. Энэ санал, санаачлагыг олон улсын хамтын нийгэмлэг хүлээн зөвшөөрч Рио+20 хурлын үр дүнгийн баримт бичиг болох “Бидний хүсч буй ирээдүй” тайланд тусгасан байна.

2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар Газрын доройтлыг тэглэх зорилтыг Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын нэг мөн хэмээн баталсан. Тогтвортой хөгжлийн зорилт 15-д “*ойн нөөцийн тогтвортой ашиглалтыг сайжруулах, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг тэглэх ба нөхөн сэргээж, биологийн төрөл зүйлийн хомсдлыг зогсоож эх газрын экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх*” гэж заажээ. Энэхүү зорилтын хүрээнд газрын доройтолд чиглэсэн 15.3 зорилтыг “*Цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах, ялангуяа цөлжилт, ган, үер усаар элэгдсэн газрыг нөхөн сэргээх замаар 2030 он гэхэд эх дэлхийн газрын доройтлыг тэглэх*” гэж томъёолсон байна (UN General Assembly, 2014).

ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ ТЭГЛЭХ ЗОРИЛТЫГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?

НҮБ-ын гишүүн улс бүр, ЦТК-ийн оролцогч тал бүр үндэсний онцлог болон тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх дэлхийн нийтийн чиг хандлагыг тусган өөрийн орны зорилтыг тодорхойлох үүрэг хүлээнэ. Өнөөдрийн байдлаар 108 улс газрын доройтлыг тэглэх өөрийн зорилтыг тодорхойлоод байна.

НҮБ-ын ЦТК нь Газрын доройтлыг тэглэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Засгийн газар хоорондын ажлын бүлэг (IWG) нь зорилтуудыг нарийвчлан тодорхойлох, зорилтыг хэрэгжүүлэх болон түүнд хяналт тавих бодит үйл ажиллагааны хувилбаруудыг тогтоох, нөөцийг бүрдүүлэх стратеги боловсруулах чиглэлд ажиллаж байна;
- Газрын доройтлыг тэглэх хөтөлбөр нь нийт 14 улс оронд газрын доройтлыг тэглэх загвар төслүүд хэрэгжүүлж олон нийт болон хувийн хэвшлийн салбарт газрын доройтлыг тэглэх үйл ажиллагаанд техникийн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх ажлуудыг хэрэгжүүлж байна;
- Газрын доройтлыг тэглэх сан байгуулах ажлыг санаачлаад байгаа бөгөөд ингэснээр газрын доройтлыг тэглэх стратегийг шинэчлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан хөрөнгө оруулалтын суурийг бүрдүүлж доройтсон газрыг нөхөн сэргээх том хэмжээний төслүүдийг санхүүжүүлэх, орон нутагт үр ашгаа өгөх дунд болон жижиг төслүүдийг санхүүжүүлэх боломж бүрдэх юм;
- Хөрсний Манлайлал Академи төсөл нь мэдлэг солилцох ба сургалт явуулах платформыг бий болгоход чиглэсэн бөгөөд ингэснээр Газрын доройтлыг тэглэх зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхийг шийдвэр гаргагчдад өгөх юм.



ҮНДЭСНИЙ ЗОРИЛТ БА ШАЛГУУРУУД

НҮБ-ын ЦТК-ийн талууд төрөл бүрийн бодлого болон механизм ашиглан өөрийн орны түвшний зорилтуудыг тодорхойлсноор эцсийн дүндээ хувийн хэвшил болон тэдгээрийн орон нутагт явуулах үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэх юм.

Мэдээж хэрэг юуны түрүүнд улс орнууд өөрийн газрын нөөцийг үнэлж, газар ашиглах төлөвлөгөөг боловсронгуй болгох замаар өөрийн хууль, зохицуулалтын баримт бичгүүдээ шинэчлэн газрын доройтлыг бууруулах, газрын тогтвортой менежментийг урамшуулах, газрыг нөхөн сэгээх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Энэ нь цаашлаад бодлого, хууль эрхзүйг илүү үр дүнтэй хэлбэрт хувиргах, газрыг илүү зохистой ашиглах нөхцлийг бий болгоно.

Энгийн үгээр илэрхийлбэл газрын доройтлыг тэглэхийн үндсэн зорилго нь орон нутаг, бүс нутаг, үндэсний хэмжээнд эрүүл, бүтээмжит газрын нөөцийг (хөрс, ус, биологийн төрөл зүйл г.м.) сайжруулах, тэлэх явдал юм (UNCCD, 2014). Энэ нь 2 төрлийн үйл ажиллагаанаас бүрдэнэ:

- Газрын Тогтвортой Менежмент ба нөхөн сэргээлт;
- Экосистемийг сайжруулах.

НҮБ-ын ЦТК-ийн үзэж буйгаар газрын доройтлыг тэглэх нь дүйцүүлэх буюу нөхөн төлөх үйл ажиллагаа биш бөгөөд энэ төрлийн хамгааллын хэлбэрийг газрын доройтлыг улам нэмэгдүүлнэ гэж үзжээ. Газрын доройтлыг тэглэх ажлын зорилго нь хойшид доройтсон газрын талбайг нэмэгдэхээс сэргийлэх, газрын нөөц баялгийн бүтээмжийг нэмэгдүүлэх болон сайжруулах явдал юм.

Улс орнууд болон бизнесүүд Газрын Доройтлыг Тэглэх ажлын үр дүнгээ хэмжиж үнэлэх учир НҮБ-ын ЦТК ба түүний хамтрагч байгууллагууд шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж байна. Зорилтын хүрээнд ашиглагдах хамгийн гол шалгуур бол газрын доройтлын хандлага (га, км 2 эсвэл нийт нутагт эзлэх хувь) болно. Эдгээр хандлага нь газар нутаг доройтож байгаа эсвэл нөхөн сэргээлт явагдаж байгаагаас хамааран өсөх эсвэл буурах хандлагатай

байна. Газрын доройтлыг хэмжих болон хэмжилтийг баталгаажуулах ажлыг үндсэн 4 шалгуурын хүрээнд хэрэгжүүлнэ.

Шаталсан тогтолцоог энд санал болгож байгаа бөгөөд шат ахих тусам мэдээллийн илтгэх байдал улам нарийвчлагдахаар зохион байгуулагдсан байна.

- Шат 1: Газрын бүрхэвч ба газар ашиглалтанд гарах өөрчлөлт
- Шат 2a: Газрын бүтээмжид ажиглагдах хандлага
- Шат 2b: Хөрсний органик нүүрстөрөгчийн хэмжээнд гарах өөрчлөлт
- Шат 3a: Биологийн төрөл зүйл ба экосистемийн үйлчилгээнд гарах өөрчлөлт
- Шат 3b: Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд ажиглагдах өөрчлөлт.


Шалгуур бүрт харгалзах улс орнуудын боловсруулсан үндэсний мэдээллийг НҮБ-ын ЦТК-ийн Нарийн бичгийн дарга нарын газарт Европын Холбооны Хамтарсан Судалгааны Төвийн дэмжлэгтэйгээр цуглуулна. Эдгээр шалгуурыг тооцох аргазүй нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, стандартад, ялангуяа уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээнд УАӨЗГХХ-ны аргазүйд, харгалзуулан боловсруулна.

НҮБ-ын ЦТК өөрийн хамтрагч байгууллагуудтай хамтран шинжлэх ухааны үндэслэлтэй суурь мэдээллийг бүрдүүлэхийг янз бүрийн зөвлөлдөх ажлын хүрээнд бүрдүүлж газрын доройтлыг тэглэх үйл ажиллагааг гүйцэлдүүлэх болон мониторинг хийх үндсийг тавьж байна.

ТАВАН ШАЛГУУРЫГ ХЭРХЭН ХЭМЖИХ ВЭ?

Шат 2а: Газрын бүтээмжид ажиглагдах хандлага

Газрын бүтээмж дор нэгж хугацаанд нэгж талбайн анхдагч цэвэр бүтээгдэхүүнийг ойлгоно. Энэ үзүүлэлт нь хөрс, газрын ерөнхий чанарыг илтгэх ба энэ нь хүнсний үйлдвэрлэл, эх газрын экосистемийн ус, эрчим хүч, шимт бодисын эргэлт, нүүрстөрөгчийн шингээлт болон төрөл зүйлийн амьдрах орчны суурь нөхцлийг илтгэнэ. Бүтээмжит байдалд гарах өөрчлөлтийг бусад мэдээллийн хамт боловсруулснаар хөрс, газар доройтож байна уу эсвэл нөхөн сэргэж байна уу гэдгийг илтгэж чадна. Газрын бүтээмжийг тодорхойлоход орон зайн хувьд өндөр ялгах чадвартай урт хугацааны цувааг бий болгох хэрэгтэй. Энэ төрлийн аргазүй бүрдсэн бөгөөд суурь жилийн төлөв байдлыг илтгэх дэлхийн хэмжээний мэдээлэл ч бүрдсэн.



Шат 1: Газрын бүрхэвч ба газар ашиглалтанд гарах өөрчлөлт

Газрын бүрхэвч ба газар ашиглалтын өөрчлөлт нь хөрс, газрын доройтол болон нөхөн сэргэлтийн төлөв байдлын анхдагч төлөвийг илтгэнэ. Энэ шалгуур нь газрын төлөв байдал, түүний бүтээгдэхүүн, үйлчилгээнд шууд нөлөө үзүүлэх үйл ажиллагааг илрүүлэхэд чиглэх бөгөөд газар ашиглалтын үнэлгээнд орлуулан хэрэглэж болно. Үүнийг дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн ангиллын (жишээ нь НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагын (FAO) газрын бүрхэвчийн ангиллын систем) дагуу газрын бүрхэвчийн ялгаатай ангиудын эзлэх талбайг хувиар илэрхийлж хэмжиж болно. Энэ шалгуур үзүүлэлт нь газрын бүрхэвч, газар ашиглалтын ангиудыг тодорхой хугацааны давтамжтайгаар харьцуулж болохуйц аргазүйгээр зураглахыг шаардана.

Шат 2b: Хөрсний органик нүүрстөрөгчийн хэмжээнд гарах хандлага

Эдгээр хандлага нь нүүрстөрөгчийн урсгалыг хэмжихэд хэрэглэгдэх бөгөөд хөрсний чанарыг ерөнхийд нь үнэлэх чухал шалгуур болно. Хөрсөн дахь органик нүүрстөрөгчийн агууламж нь ургамал ургалт, хөрсний үржил шимийг сайжруулахад чухал үүрэгтэй оролцохоос гадна усыг зохицуулна. Иймээс хөрсөн дэх органик нүүрстөрөгчийн агууламж өсөх хандлага нь газрын тогтвортой менежментийн арга хэлбэр хөгжсөнийг илтгэнэ. Хөрсөн дахь органик нүүрстөрөгчийн агууламжийг сайжруулснаар уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, биологийн төрөл зүйлийг хамгаалахад ч мөн чухал эерэг өөрчлөлтийг авчирч болох юм. Хөрсний органик нүүрстөрөгчийн агууламжийг лавлагаа гүнд агуулагдах нөөц эсвэл агууламжаар нь тодорхойлж болно. Лавлагаа гүн гэдэгт хөрсөнд агуулагдах нүүрс төрөгчийн хэмжээ илрэх гүнийг авч үзэх ба энэ нь байгалийн бүс бүслүүр, хөрсний хэв шинжүүдэд харилцан адилгүй байж болно. НҮБ-аас лавлагаа гүнг хөрсний хэв шинжид тохируулах ажлыг одоогоор стандарт байдлаар боловсруулж байна. Энэ шалгуур үзүүлэлтийг бодитоор үнэлэхийн тулд тодорхой хугацааны давтамжтайгаар хөрсний лавлагаа гүнд агуулагдах органик нүүрстөрөгчийн орон зайн зураглал хийх шаардлагатай. Хөрсний органик нүүрстөрөгчийг загварчлах аргазүй бүрдсэн бөгөөд суурь оны мэдээллийг дэлхийн хэмжээнд бүрдүүлээд байна.



Шат 3a: Биологийн төрөл зүйл ба экосистемийн үйлчилгээнд гарах хандлага

Энэ шалгуурыг болон түүнд гарах өөрчлөлтийн хандлагыг хэрхэн тодорхойлох асуудал одоо хэлэлцэгдэж байгаа юм. Олон улсын хамтын нийгэмлэг биологийн төрөл зүйлийн шалгуур үзүүлэлт ба түүний хэмжих арга дээр харилцан тохиролцоод байна.

Шат 3b: Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд ажиглагдах хандлага

Энэ шалгуурыг хөдөөгийн ядуурлын түвшин, цэвэр усаар хангагдсан хүн амын эзлэх хувь, тэжээлийн хомсдолд буй таваас доош насны хүүхдийн эзлэх хувь (15), эсвэл өртөмтгий бүс нутаг дахь орлогын тэгш бус байдал зэрэг үзүүлэлтийг тодорхой хугацааны давтамжтайгаар хэмжих замаар бүрдүүлж болно.



ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ ТЭГЛЭХ ЗОРИЛТЫГ ДЭМЖСЭНЭЭР БИЙ БОЛОХ БИЗНЕС БОЛОМЖ

ЯАГААД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Газрын доройтлыг тэглэх дэлхийн болон үндэсний зорилтыг гүйцэлдүүлэхэд бизнесийн байгууллагуудын үүрэг их юм. Учир нь тэдгээрийн үйл ажиллагаа нь түүхий эд байна уу, үйлдвэр байгуулах байна уу шууд болон дам утгаар газар, түүний нөөцийг ашиглаж байдаг. Бизнесийн байгууллагууд үндэсний болон тив дэлхийн газрын доройтлыг тэглэх зорилтыг дэмжих эсэхээ өөрийн сонголтоор шийдэх эрхтэйн зэрэгцээ энэ зорилтыг өөрийн үйл ажиллагаа болон нийлүүлэлтийн хэлхээндээ нэвтрүүлэх эсэх талаар шийдвэр гаргаж болно.

Газрын доройтлыг тэглэх зорилтыг дэмжсэнээр компаниудад хэд хэдэн үр ашиг бий болно. Газрын доройтлыг тэглэх зорилтыг хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламжийн тэсвэрлэх чадвар нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүх үе шатанд хангагдаж түүхий эдийн хүртээмжийн аюулгүй байдал нэмэгдэнэ. Үүнээс гадна мониторинг судалгааг тогтмол хийснээр өөрийн бизнесийн газар болон экосистемийн үйлчилгээнд үзүүлэх нөлөөг бодитоор үнэлж, бусдад мэдээлснээр

байгууллагын нэр хүндийг ч мөн өсгөх талтай. Газрын доройтлыг тэглэх бодлогыг хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлснээр бизнесийн шинэ боломжууд нээгдэх, бизнес загвараа өөрчилж болох юм.

Газрын доройтлыг тэглэх бодлогыг нэвтрүүлснээр тогтвортой байдлыг өөрийн нийлүүлэлтийн хэлхээний бүх үе шатанд нэвтрүүлж болох ирээдүйн компаниудад цаашид хөгжих өргөн боломжийг олгоно. Газрын нөөц баялагийг ашигладаггүй компани, аж ахуйн нэгжүүд ихэвчлэн энэ асуудлыг өөрийн бизнесийн нэг хэсэг гэж хардаггүй, тиймээс ч түүхий эдийн үнэ, хүртээмж зэрэг гадаад хүчнүүдээр дамжуулан ойлгодог. Нөгөө талаас газрын тогтвортой менежментийн мэдлэг ба түүнд хөрөнгө оруулах явдал нь газартай шууд хамааралтай үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн хэмжээнд илүү өндөр байна (16). Газрын доройтлыг тэглэх бодлогыг өөрийн бизнесийн бүх үе шатанд нэвтрүүлснээр эерэг өөрчлөлтүүд нэмэгдэж, үр ашиг тогтвортой өсөх боломжтой.

ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ ТЭГЛЭХ БИЗНЕС БОЛОМЖУУД

Газрын доройтлыг бууруулах замаар газрын доройтлыг тэглэх зорилтод хүрэх үйл ажиллагаа нь газрын тогтвортой менежментийг нэвтрүүлж цаашид экосистемийн өөрчлөлтийг сааруулахад чиглэнэ. Бизнесүүдийн хувьд газрын доройтлыг тэглэх нь “доройтуулах-үгүйрүүлэх-нүүх” гэсэн хуучин үзлээс татгалзаж “сэргээх-тогтворжуулах-хамгаалах” шинэ баримтлалыг хөгжүүлэхээс эхлэнэ. Энэ нь менежментийн дараах хэрэгслийг үе шаттай нэвтрүүлснээр бүрдэх юм. Үүнд:

- Газрын тогтвортой менежментийг нэвтрүүлж одоо байгаа доройтлыг бууруулж ирээдүйд болзошгүй доройтлоос сэргийлэх. Энэ нь хөдөө аж ахуйн ойжуулалт, хамгааллын газар тариалан, ойн тогтвортой менежмент, хаягдлын менежмент, хаягдлыг дахин ашиглах, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах замаар биомасст үзүүлэх нөлөөг бууруулах, усны цогц менежмент, тогтвортой аялал жуулчлал, биологийн төрөл зүйлийн хамгаалал, хортон шавьжийн менежмент зэрэг аргууд байж болно.
- Доройтсон болон орхигдсон бүтээмжит газруудыг нөхөн сэргээх, байгалийн экосистемийг сэргээх замаар амьдралыг тэтгэгч, дам үр ашгийг бизнес болон ард иргэдэд хүргэх, бүтээмжит газрын талбайг тэлэх (17).

Өөрийн үйл ажиллагаандаа газрыг шууд ашиглах компани, хувийн хэвшлийн аж ахуйнуудын хувьд дээрхи үйл ажиллагааг үйлдвэрлэлийн нэг хэсэг болгон ажиллахыг зөвлөмж болгоно. Харин түүхий эд болон бусад нөөцийг гуравдагч эх үүсвэрээс хангаж буй газрын нөөцөөс хамааралгүй үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн хувьд өөрийн нийлүүлэлтийн хэлхээнд энэ төрлийн үйл ажиллагааг дэмжих замаар газрын доройтлыг тэглэх зорилтод хувь нэмэрээ оруулах боломжтой. Тухайлбал, түүхий эд нийлүүлэгч байгууллагадаа дээрхи үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх шаардлага тавих, хамтрагч байгууллагууддаа дээрхи арга хэмжээг нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх гэх мэт. Энэ нь дунд, жижиг оврын газар тариалан болон мал аж ахуй эрхлэгч нарт ихээхэн хөшүүрэг болох бөгөөд ийм шинэчлэл хийлгүйгээр газрын доройтлыг тэглэх зорилтыг гүйцэлдүүлэх боломжгүй юм.

Газрын доройтлыг тэглэх бизнес зорилго нь дээрхи арга замыг нэвтрүүлэхэд орших бөгөөд эдгээрийг хамгааллын хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн ойжуулалтыг нэвтрүүлсэн талбайгаар хэмжиж, дүгнэж болно. Түүнчлэн өөрийн нийлүүлэлтийн хэлхээний хэмжээнд газрын тогтвортой менежментийг нэвтрүүлснээр бий болох экосистемийн үйлчилгээний урсгал мөн л энэ чиглэлд гарсан эерэг өөрчлөлтийн нэг шалгуур болохыг анхаарах нь зөв.



ХОЛБОГДОХ ЗОРИЛТ БА САНААЧЛАГУУД

Газрын доройтлыг тэглэх зорилттой ижил төсөөтэй зорилго агуулсан санал, санаачлагууд нь энэхүү зорилтыг тэлэхэд чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй. Тухайлбал, 2014 онд батлагдсан Ойн тухай Нью Йоркийн Деклараци нь 2030 он гэхэд 350 сая га талбайг нөхөн сэргээх зорилтыг дэвшүүлсэн, харин Бонны сорилт хөтөлбөр нь 2020 он гэхэд 150 сая га доройтсон газар ба огтлогдсон ойг нөхөн сэргээнэ гэсэн зорилтыг тавиад байна.

Бонны санаачлага Африк, Хойд, Төв болон Өмнөд Америкийн нийт 11 улсаас 60 сая га талбайг нөхөн сэргээх амлалтыг одоогоор аваад байгаа бөгөөд энэ нь дэвшүүлсэн зорилтын 39 %-тай тэнцэх юм. Хамтын хүчээр эдгээр улс амлалтаа биелүүлснээр 4.73 гигатонн нүүрстөрөгчийн давхар ислийг шингээх ба үүний эдийн засгийн үр ашиг 15.826 тэрбум доллартай тэнцэх аж.

Бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлж буй зорилтуудын нэг жишээ нь 20х20 Санаачлага юм. Үүгээр Латин Америк болон Карибын тэнгисийн улс орнууд 2020 он гэхэд доройтсон гэж тооцогдох талбайн 20 сая га талбайг нөхөн сэргээх зорилтыг тавиад байна.

Газрын доройтлыг тэглэх бодлого нь томоохон бизнесүүдийн тогтвортой байдлын бодлогод ч хэдийн тусгалаа олоод байгаа билээ. Тухайлбал, Рио Тинто “цэвэр эерэг нөлөө” зорилтыг (Rio Tinto, 2013) биологийн



Net Positive: a growing movement....



ЦЭВЭР ЭЭРЭГ НӨЛӨӨ (NPI)

Цэвэр эерэг нөлөө нь нөхөн төлбөрийн тогтолцоогоор дамжуулан биологийн төрөл зүйлд учирч буй сөрөг нөлөөллийг тооцож төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа бүс нутагт эерэг өсөлтийг бий болгохыг зорино. Биологийн төрөл зүйлд гарах эерэг өөрчлөлтийг төсөл, хөтөлбөр хэрэгжихээс өмнө тооцогдсон биологийн төрөл зүйлийн суурь мэдээлэлд түшиглэн үнэлнэ.

Байгаль хамгааллын өнцөгөөс цэвэр эерэг нөлөөллийг бий болгосноор дараах үр дүнд хүрнэ гэж тооцдог. Үүнд:

- төрөл зүйл, ургамлын бүлгэмдлийн дотоод болон гадаад олон янз байдал нэмэгдэнэ;
- төрөл зүйл, ургамлын бүлгэмдлийн урт хугацааны амьдрах чадвар сайжирна;
- Зүйлийн бүлгэмдэл болон экосистем дэх экологийн болон хувьсал өөрчлөлтийн үйл явц тогтворжино.

Эх үүсвэр: IUCN, 2015

төрөл зүйлийг хамгаалах чиглэлд нэвтрүүлсэн, Сингента корпораци хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 10 сая га талбайн үржил шимийг сайжруулах бодлого хэрэгжүүлж байна. Харин Юниливер компани нь мод огтлолыг зогсоохыг өөрийн тогтвортой бизнесийн бодлогод суулгаж өгчээ. Рио Тинтогийн хэрэгжүүлж буй “цэвэр эерэг нөлөө” зэрэг зорилтууд нь бусад олборлох үйлдвэрлэл эрхэлдэггүй аж ахуйн нэгжүүдэд хэрхэн нөлөөлөхийг тодорхойлсноор газрын доройтлыг тэглэх бодлого хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, нийлүүлэлтийн хэлхээнд ямар эерэг нөлөө авч ирэхийг тооцоолж болох талтай.

Одоогоор цэвэр эерэг нөлөө гэдгийг тодорхойлсон олон улсын тодорхойлолт байхгүй байгаа хэдий ч Олон Улсын Байгаль Хамгааллын Холбоо (IUCN)-ноос энэ бодлого нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй зэрэг бусад салбарт хэрхэн хэрэгжиж болох талаархи судалгааны тайлан гаргасан нь хоёр өөр арга барилын ижил төсөөтэй болон ялгаатай талуудыг илрүүлэхэд чухал дэмжлэг үзүүлнэ (IUCN, 2015). Цэвэр эерэг нөлөө ба газрын доройтлыг тэглэх бодлого хоорондын гол ялгааг бодитоор үнэлснээр нөхөн төлбөрийн тогтолцоо гол зорилтыг гүйцэлдүүлэхэд ямар эерэг өөрчлөлтийг авч ирэхийг тооцох боломжийг олгоно.

НҮБ-ын ЦТК-ийн одоогийн баримталж буй бодлогод “Газрын доройтлыг тэглэх зорилт нь зах зээлд суурилсан дүйцүүлэн хамгаалах буюу нөхөн төлбөрийн системийг дэмжихгүй байгаа юм. Учир нь энэ арга барил нь асуудлын цогцолбор шинжийг харгалзаагүй, олон асуудал дагуулсан, ерөнхийдөө үр ашиг муутай бодлого гэж тооцдог” хэмээн үзэж байна (UNCCD).

Хөдөө аж ахуй, газар тариалан зэрэг газартай шууд холбоотой үйл ажиллагаа явуулах бизнесийн салбарын хувьд Газрын доройтлыг тэглэх зорилт нь мод огтлолыг зогсоох бодлоготой хоршин хэрэгжиж болно (<http://the-forestdialogue.org>). Энэ хоёр бодлогын төсөөт байдал болон ялгааг судлан тодорхойлох нь газрын доройтлыг тэглэх зорилтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй. Үүнээс гадна аж ахуйн нэгжүүд мод огтлолыг зогсоох бодлогын хэрэгжилтийг хэрхэн хэмжих, түүнд яаж мониторинг хийх асуудлыг судлан тогтоох шаардлага ч бий.

МОД ОГТЛОЛЫГ ЗОГСООХ

Компани, аж ахуй нэгж мод огтлолыг зогсоохын тулд өөрийн нийлүүлэлтийн хэлхээнд мод огтлолын үйл ажиллагаанаас бий болсон түүхий эдийг хэрэглэхийг бууруулах юм.

Хамтын хүчээр мод огтлолыг зогсоох үйл ажиллагаа нь тодорхой үе шаттай хэрэгжих бөгөөд компани аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны төрлөөс хамаарна. Энэ зорилтын хүрээнд компаниуд гол төлөв баталгаажуулалтын схемийг нэвтрүүлсэн байх бөгөөд нийлүүлэгч мод огтлохгүйгээр түүхий эд үйлдвэрлэсэн эсэхийг хянах хяналтын тогтолцоог бүрдүүлж өгдөг.

Эх үүсвэр: Carbon Disclosure Project, 2014




syngenta foundation
for sustainable
agriculture



БОДЛОГО ТЭЛЭХЭД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ:

- Засгийн газрын зохицуулалтыг бий болгож хэрэгжүүлэх;
- Тогтвортой нийлүүлэлт, хэрэглээ, бүтээгдэхүүнийг бий болгох эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх;
- Хөрөнгө оруулалт ба санхүүжилтийг хангалттай бий болгосон байх;
- Баталгаажсан бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх;
- Салбар дундын болон үйлдвэрлэл хоорондын хамтын ажиллагааг дэмжих.



БОДЛОГЫГ ХЭРХЭН ТЭЛЭХ ВЭ?

Газрын доройтолгүй эдийн засгийн орчин бүрдүүлэх нь их хэмжээний хөрөнгө оруулалт болон нээлттэй эрхзүйн зохицуулалтыг шаардана. Урамшууллын зөв тогтолцоог хөгжүүлснээр хувийн хэвшлийг өргөн хүрээтэй татан оролцуулж, энэ бодлогыг тэлж, тогтвортой хөгжлийг хангах боломж бүрдэх юм. Газрын доройтлыг тэглэх зорилтыг хангаж буй аж ахуйн нэгжүүдийн нэр хүндийг өсгөх, энэ үйл явцын хүрээнд анхдагч байхын давуу талыг бий болгосноор бизнесийн орчныг бүрэн татан оролцуулах боломжтой. Эерэг суурь нөхцлийг бий болгосноор холбогдох бизнесийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын эргэн төлөлт ч урт хугацаанд илүү ашиг авчирна гэж үздэг. Иймд дээр дурьдсан бүх нөхцлийг зохистой, хүртээмжтэй бүрдүүлснээр бусдад үлгэр дууриал болохоос гадна илүү таатай бодлогын орчин, илүү их хөрөнгө оруулалтын боломжууд бүрдэнэ.

Бизнес, олон нийт, хувь хөрөнгө оруулагчид болон бодлого тодорхойлогчид нэг зүгт нэгдэн ажиллаж чадвал газрын доройтлыг тэглэхэд шаардагдах хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа бүрэн хэрэгжинэ. Энэ нь урт хугацаанд тогтвортой бизнесийн загварыг бүрдүүлээд зогсохгүй санхүүгийн эргэн төлөлтийг нэмэгдүүлж хүнс тэжээл, ус, эрчим хүчний аюулгүй байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ (The Global Mechanism, 2015).

Газрын доройтлыг тэглэх сан байгуулах санаачлага нь газрын доройтлыг тэглэх зорилтыг гүйцэлдүүлэх санхүүгийн хөшүүргийн нэг жишээ юм. НҮБ-ын ЦТК-ийн мэдлийн дор байгуулагдахаар зэхэж буй энэ сангийн гол зорилго нь зохион байгуулалттай бүтцийн хүрээнд газрын доройтлыг тэглэх бодлогыг тэлэх үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино. Даян дэлхийн энэ механизмыг үндэсний газрын доройтлыг тэглэх зорилт, үйл явцтай уялдуулснаар зорилтот санхүүжилт, өргөн хэмжээний хөрөнгө оруулалт, бүс нутгийн хамтын ажиллагааг тодорхой зохицуулалтын хүрээнд бий болгож жил бүр 12 сая га доройтсон газрыг бүтээмжит газар болгон нөхөн сэргээх боломжтой.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН АЛХАМ

Газрын доройтлыг тэглэх бодлогыг өөрийн бизнест нэвтрүүлснээр үндэсний болон даян дэлхийн томоохон асуудлыг шийдвэрлэхэд та өөрийн хувь нэмэр, оролцоог оруулж байгаа төдийгүй бизнесийн тогтвортой загварыг хөгжүүлж, нийлүүлэлтийн хэлхээгээ эрсдэлээс хамгаалж чадах юм.

Гэхдээ компани, хувийн хэвшлийнхэн газрын доройтлыг тэглэх бодлогод бүрэн дүүрэн оролцохын тул хэд хэдэн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байгаа юм. Юуны түрүүнд бизнесийн салбараас хамааран газрын доройтлыг тэглэх ямар үйл ажиллагаа явуулж болохыг тодорхойлох нь чухал. Түүнчлэн зөв тодорхойлолт, холбогдох шалгуурууд болон хэрэгжүүлэх хугацааг бодитоор тодорхойлох нь бизнесийн байгууллагуудын оролцоог бий болгох гол нөхцөл болно.

Иймд БОАЖЯ, Газарзүй, Геоэкологийн хүрээлэн, Цөлжилтийн судалгааны төвөөс бизнесийн байгууллагууддаа энэхүү товхимлоор дамжуулан Бизнесийн хүрээнд газрын доройтлыг тэглэх санаачлагад нэгдэхийг хүсч байна. Юун түрүүнд та бүхний оролцоотойгоор бидний дэвшүүлж буй дараах 2 асуудлыг шийдвэрлэхийг хүсч байна. Үүнд:

- Газрын доройтлыг тэглэх бодлогыг бодит үйл ажиллагаа болгох
- Газрын доройтлыг тэглэх бодлогод бизнесийн байгууллагуудын оруулах хувь нэмрийг бодитоор тогтоох.

Бид газрын доройтлыг тэглэх бодлогод бизнес, хувийн хэвшлийн оролцоог маш чухал үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд та бүхэн үйл ажиллагаандаа газрын тогтвортой менежмент болон газрыг нөхөн сэргээх арга хэмжээг нэвтрүүлснээр араасаа олон олон эерэг өөрчлөлтийг авчирна гэдэгт найдаж байна. Энэ чиглэлийг НҮБ-ын ЦТК өөрийн талуудын бага хурлаас сайшаасан бөгөөд гишүүн улс орнууд ч өөрийн түвшинд энэ санаачлагыг хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон байдаг.

АШИГЛАСАН НОМ, ХЭВЛЭЛ

ELD Initiative (2013). ELD Business Brief - Opportunity lost: Mitigating risk and making the most of your land assets. www.eld-initiative.org

ELD Initiative (2013). The rewards of investing in sustainable land management. Interim Report for the Economics of Land Degradation Initiative: A global strategy for sustainable land management. www.eld-initiative.org

FAO (2011). The State of the World's Land and Water Resources for Food and Agriculture. www.fao.org

Global Land Indicators Initiative (GLII) expert meeting (2015). Proposal for land and soil indicators to monitor the achievement of the Sustainable Development Goals (SDGs)". www.gltn.net.

Global Mechanism (2015). Land Degradation Neutrality Fund. Fact sheet.

IUCN (2015). No Net Loss and Net Positive Impact Approaches for Biodiversity.

Rio Tinto commitment: Rio Tinto and biodiversity - working towards Net Positive Impact. http://www.riotinto.com/ourcommitment/features-2932_8529.aspx

Forests Dialogue, 2014. Understanding Deforestation Free. <http://the-forestsdialogue.org/initiative/understanding-deforestation-free-udf>

Syngenta, 2014. "One planet. Six commitments". Good Growth Plan. www.syngenta.com/global/corporate/en/goodgrowthplan/measurement/Pages/measurement.aspx

The Global Mechanism, 2015. Land Degradation Neutrality Fund. Scoping paper.

UN General Assembly resolutions on sustainable development (2014).

UNCCD (2013). UNCCD impact indicator refinement: issues at stake. Document UNCCD COP11.

UNCCD (2014). Land Degradation Neutrality: Resilience at local, national and regional levels.

UNCCD. Desertification, Land Degradation and Drought (DLDD): Some Global Facts & Figures. www.unccd.int

UNCCD. Land Degradation Neutrality – Frequently Asked Questions. www.unccd.int/Lists/SiteDocumentLibrary/FAQ/LDN.pdf

UNCCD. The 10-year strategic plan and framework to enhance the implementation of the Convention. Decision 3/


COP.8. <http://www.unccd.int/Lists/SiteDocumentLibrary/10YearStrategy/Decision%203COP8%20adoption%20of%20The%20Strategy.pdf>

Unilever, 2014. Combating deforestation. <http://www.unilever.com/sustainable-living/transformational-change/eliminating-deforestation/>



WRI. "Global Map of Forest Landscape Restoration Opportunities". <http://www.wri.org/resources/maps/global-map-forest-landscape-restoration-opportunities>

Мандах Н., Даш Д., Хауленбек А. нар, 2016. Цөлжилттэй тэмцэх арга хэмжээ, технологи. УБ., "Адмон" хэвлэлийн газар, 268 х.

Монгол орны цөлжилтийн атлас. Ред. Цогтбаатар Ц., Хөдөлмөр С., Улаанбаатар, Адмон. 2013. 134 х.



Тогтвортой хөгжилд хөтлөх бизнес шийдлийг
хамтдаа эрэлхийлье



Холбоо барих:

ШУА-ИЙН ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН,
БАНУУН СЭЛБИЙН 15, 4-Р ХОРОО, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ,
УЛААНБААТАР-15170, МОНГОЛ УЛС
УТАС: +976-11-319316
Фэйсбүүк: Газрын доройтлыг тэглэе

